



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

Коронавируст халдвараас
урьдчилан сэргийлэх бэлэн
байдлыг хангах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.8 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36, А/93 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах зорилгоор 2020 оны 02 сарын 18-ны өдрөөс эхлэн өндөржүүлсэн бэлэн байдлыг цуцлах хүртэлх хугацаанд 24 цагийн турш хариуцлагатай 4 ээлжийн эргүүлийг ажиллуулсугай.
2. Өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж, шаардлагатай үед ажиллах ажиллагсадын бэлтгэлийг хангуулж ажиллахыг Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга /Т.Алимаа/, Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч /Ё.Улсболд/, Технологийн тасгийн эрхлэгч /Н.Халиун/, Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч /М.Цэрэндэжид/-д тус тус үүрэг болгосугай.
3. Болзошгүй гамшиг, осол, хордлого, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах төлөвлөгөөг мөрдөн, эмнэлгийн яаралтай тусламж, хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн мэргэжлийн ангийн нарийн бичгийн дарга /Ч.Далайцэрэн/, Хүний халдварт өвчний дэгдэлтийн үеийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн Эрүүл мэндийн сайдын тушаалын хэрэгжилтийг хангаж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Чанар, цусны сонор сэрэмжийн албаны дарга /Т.Алимаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

080046


4. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахад шаардлагатай хавсралтад заасан хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодисын зардлыг эм эмнэлгийн хэрэгслийн зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Ө.Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2020 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн
А.13 дугаар тушаалын хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХАД ШААРДЛАГАТАЙ
ХАМГААЛАХ ХУВЦАС ХЭРЭГСЭЛ,
ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫН ТӨСӨВ

№	Шаардагдах материал	Хэмжиг нэгж	Тоо, ширхэг	Нэгж үнэ төгрөг	Нийт үнэ төгрөг
1	Нэг удаагийн комбинзон	ш	50	20,000	1,000,000
2	Нэг удаагийн амны хаалт	ш	2500	150	375,000
		ш	2500	600	1,500,000
3	Халдваргүйтгэлийн бодис- Клорсепт 17	Фл	3	48,000	144,000
4	Гар халдваргүйжүүлэх бодис -Anioskin	5л	3	92,500	277,500
5	Гадаргуу халдваргүйжүүлэх бодис - Surfanios premium	5л	1	155,000	155,000
Нийт үнэ					3,451,500